



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/447

Есөнбулаг

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан ажлууд, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг олон нийтэд түгээх, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг ард иргэдэд сурталчлан таниулах зорилгоор орон нутгийн "Миний нутаг" телевизтэй гэрээ байгуулсугай.

2. Гэрээг хууль журамд нийцүүлэн байгуулж, шаардагдах 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.АМГАЛАНБААТАР

